



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/613

Ховд

Орон нутгийн төсвийн
хуваарьт өөрчлөлт оруулах тухай


Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль болон төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7.1 дэх заалт, Сангийн сайдын 2020 оны 165 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн А/13 дугаар захирамжаар баталсан төсвийн орлогын сар, улирлын хуваарийг 1 дүгээр хавсралтаар, А/72 дугаар захирамжаар баталсан аймгийн төсвийн зарлагын сар, улирлын хуваарийг 2 дугаар хавсралтаар, мөн А/13 дугаар захирамжаар баталсан сум, байгууллагуудад олгох санхүүгийн дэмжлэгийн сар, улирлын хуваарийг 3 дугаар хавсралтаар, аймгийн төсвөөс сумдад олгох тусгай зориулалтын шилжүүлгийн сар, улирлын хуваарийг 4 дүгээр хавсралтаар, 6 дугаар хавсралтаар батлагдсан аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний сар, улирлын хуваарийг 5 дугаар хавсралтаар, 7 дугаар хавсралтаар батлагдсан аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын сар, улирлын хуваарийг 6 дугаар хавсралтаар, 9 дүгээр хавсралтаар батлагдсан Хөшөөт хөгжил сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний сар, улирлын хуваарийг 7 дугаар хавсралтаар тус тус өөрчлөн баталсугай.

2. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан орон нутгийн төсвийн орлого, зарлага, тусгай зориулалтын шилжүүлэг, орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний сар, улирлын хуваарийг орлого, зарлагын нэр төрөл, төсөл, арга хэмжээ бүрээр дэлгэрэнгүй гаргаж батлан хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг сумдын Засаг дарга, төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.

3. Санхүүжилтийг төсвийн батлагдсан хуваарийн дагуу олгож, хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Зах А/613 Ч

02 2795